210702	Дотоод албан томилолт		98,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,809,596.00	8,507,138.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,809,596.00	8,507,138.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,924,400.00	47,727,578.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,924,400.00	47,163,578.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		564,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		55,384,766.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		0.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		0.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		54,604,766.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		26,804,766.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		27,800,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		780,000.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		780,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	154,100,5206.00	118,805,776.00
2200	Дотоод эх үүсвэрээр		118,805,776.00
220001	Барилга байгууламж	50,000,000.00	97,811,333.00

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		20,994,443.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	200,340,019.00	329,121,935.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	200,340,019.00	329,121,935.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,350,000.00	33,452,518.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	179,374,516.00	121,498,936.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,602,503.00	67,183,481.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,013,000.00	11,111,000.00
131106	Хаагдсан данс		0.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого		95,876,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Мөнххайрхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд МУ-ын Засгийн газрын 43 дугаар тогтоол, тогтмол зардлын зарцуулалт, И баримт, орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн зарцуулалттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитор Ц.Гантулга 2022 оны 3 дугаар сарын 17-ноос 2022 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Мөнххайрхан сумын Засаг дарга 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 1/32 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Мөнххайрхан сумын Засаг дарга нь Монгол улсын Үндсэн хууль болон УИХ, Засгийн газраас гарч буй хууль тогтоомжид нийцүүлэн “Төрийн үйлчилгээний шуурхай байдлыг хангаж цахим системд нэвтрүүлэх” эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд сумынхаа эдийн засаг, нийгмийн хөгжлийг эрчимжүүлж, байгаль орчин, бизнест ээлтэй ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлэх
- Төрийн үйлчилгээг чанарын шинэ шатанд гаргаж, ард иргэдийнхээ амьдрах орчныг сайжруулах, аж амьдралыг дээшлүүлэх олон талт үйл ажиллагаа явуулах
- Мал аж ахуйг эрчимжүүлэх, залуу малчдыг малжуулах гэсэн олон талт үйл ажиллагаа явуулах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Малын тоо толгойн албан татварын тухай хууль*
- *Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль*
- *Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль*
- *Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай*
- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.

Сумын нэгтгэсэн санхүүгийн тайланд мөрдөх тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн и-баланс цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

Мөнххайрхан сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мөнххайрхан сумын ТТЗ-ын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зарлагын 2517.6 сая төгрөгөөс 2 хувиар тооцон 50.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 201.4 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мөнххайрхан сумын ТТЗ-ын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2808.8 сая төгрөгөөр буюу 63.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, цэвэр өмчийн данснууд байна.

Хүснэгт №1. Санхүүгийн байдлын тайлан

/сая. төгрөг/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
Мөнгөн хөрөнгө	65.6	290	-224.4	442.1
Авлага	190.8	148.1	42.7	77.6
Бараа материал	216.4	289.9	-73.5	134.0
Үндсэн хөрөнгө	3955.6	6509.2	-2,553.6	164.5
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4428.4	7237.2	-2,808.8	163.4
Богино хугацаат өр төлбөр	2.4	9.6	-7.2	400.0
Цэвэр хөрөнгө, өмч	4538.2	7287.9	-2,749.7	160.6
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4540.6	7297.5	-2,756.9	160.7

Эх сурвалж: Мөнххайрхан сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 65.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 290.0 сая төгрөг болж 224.4 сая төгрөгөөр буюу 442.1 хувиар өссөн байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 290.0 сая төгрөг нь Төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 190.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 148.1 сая төгрөг болж 42.7 сая төгрөг буюу 22.4 хувиар буурсан байна.

Хүснэгт №02 Авлагын үлдэгдэл

/сая.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.50	-	(0.5)
Төлбөртэй үйлчилгээний авлага			-
Байгууллагаас авах авлага	-	13.0	13.0
Хувь хүмүүсээс авах авлага	190.30	135.1	(55.2)
Зээлийн хүүгийн авлага	-	-	-
Татвар, НДШ /ОНӨААТҮГ/			-
Татаас санхүүжилтийн авлага			-
Дүн	190.8	148.1	(42.7)
Урьдчилж гарсан зардал	62.3	10.4	(51.9)
Тусгай зориулалтын сан	49.9	49.9	-
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа			-
Цалингийн урьдчилгаа			-
Дүн	112.2	60.3	
АВЛАГЫН НИЙТ ДҮН	303.0	208.4	(42.7)

Эх сурвалж: Мөнххайрхан сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд 67.2 сая төгрөгийн насжилт өндөртэй сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүү эзэлж байгаа бөгөөд оны эхэнд 190.3 сая төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 27.0 сая төгрөгийн зээл олгож 82.2 сая төгрөгийн зээл, зээлийн хүү эргэн төлөгдөж, оны эцэст 135.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба нийт зээлийн 43.1 хувь нь төлөгдсөн байна.

ОНХС-ийн авлагад бүртгэлтэй малжуулах төслийн авлага болох эхний үлдэгдэл 49.9 сая төгрөгөөс тайлант онд нэмэгдэж, хасагдсан өөрчлөлт байхгүй байна.

3.5.3 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 289.9 сая төгрөг болж 73.5 сая төгрөг буюу 34.0 хувиар өссөн нь ковид-цар тахалтай холбоотойгоор 55.3 сая төгрөгөөр эм, эм боох материал, 18.2 сая төгрөгийн аж ахуйн бусад материал үнэ төлбөргүй

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 256.9 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, үнэ төлбөргүйгээр 38.9 сая төгрөгөөр нийт 295.8 сая төгрөгөөр нэмэгдэж, 222.3 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 5531.8 сая төгрөг байсан бол оны эцэст 8322.9 сая төгрөг болж 2791.1 сая төгрөгөөр өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1921.9 сая төгрөгийн Соёл спортын цогцолбор, 589.5 сая төгрөгийн сайжруулсан авто замын бүтээн байгуулалт, аймгийн ОНХС-гаас 113.8 сая төгрөгийн авто машины гүүр, 165.9 сая төгрөгийг сумын ИТХурал, ЗДТГ-т албан конторын тавилга эд хогшил, компьютер, техник төхөөрөмж, ерөнхий боловсролын дунд сургуульд гал тогооны бүрэн тоног төхөөрөмж, Эрүүл мэндийн төвд түргэн тусламжийн “Фургон” машин авсан гэх мэт хөрөнгө бэлтгэсэнтэй холбоотой байна.

Тайлант онд 66.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн, 29.7 сая төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авсан, үнэ төлбөргүй хандиваар 2848.0 сая төгрөгөөр нэмэгдэж, акталсан, данснаас дансанд шилжүүлсэн 153.2 төгрөгөөр хөрөнгө хасагдсан байна.

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 2.4 сая, эцсийн үлдэгдэл 9.6 сая төгрөг болж 7.2 сая төгрөгөөр өссөн байна. Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 9.6 сая төгрөгийн өр байгаа нь дараа тайлангийн хугацаанд бүрэн барагдах боломжтой өглөгүүд байна.

Үүнээс: ажил олгогчтой холбоотой НДШ-ийн өглөг 8.8 сая төгрөг, ЭМД-ын санд төлөх өглөг 0.8 сая төгрөгийн үлдэгдэл байгаа ба тооцоо нийлж баталгаажуулсан байна.

3.5.7 Цэвэр хөрөнгө, өмч

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 4538.2 сая төгрөг байснаас оны эцэст 7287.9 сая төгрөг болж тайлант онд хөрөнгө оруулалтын ажлууд ашиглалтад авснаар тайлант үеийн үр дүнг 2746.9 сая төгрөг болон өсөж өмнөх үеийн үр дүн рүү залруулга хийгдээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2115.1 сая төгрөгөөр, нийт зарлагыг 2115.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Мөнххайрхан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн төсвийг аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03 өдрийн 3/03 тоот тогтоолоор 2065.6 сая төгрөгөөр анх баталж өмнө оны болон тайлант оны давсан орлоготой холбоотойгоор 2021 онд 1 удаа тодотгол хийн 2021 оны 08 дугаар сарын 05-ны 4/03 тоот тогтоолоор нийт 2151.2 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголыг сумын ИТХ-аар 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 5/06 тоот тогтоолоор 2151.2 сая төгрөгөөр 6 байгууллага, 2 сангийн төсвийг тодотгож баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 2151.2 сая төгрөгийн төсөв баталснаас 1,412.0 сая төгрөгийг улсын төсвөөс, 423.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 24.7 сая төгрөгийг ЭМДС-аас, 77.3 сая төгрөгийг ОХНС-аас санхүүжих, 1.1 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 0.4 сая төгрөгийг туслах үйл ажиллагаанаас, 27.1 сая төгрөгийг өмнөх оны үлдэгдлээс санхүүжүүлжээ. ЭМДС-гийн санхүүжилтийн үлдэгдэл 0.6 сая төгрөг тус төвийн харилцах дансанд үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 3. Төлөвлөгөө, гүйцэтгэл сая.төг

	төлөвлөгөө	гүйцэтгэл
Улсын төсвөөс санхүүжих	1,412.0	1,412.0
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,412.0	1,412.0
Орон нутгийн төсвөөс санхүүжих	500.3	500.3
Орон нутгийн төсвөөс	423.0	423.0
Орон нутгийн татварын болон татварын бус орлого	134.8	332.0
Орон нутгийн хөгжлийн сан	77.3	77.3
Нийгмийн даатгалын төсвөөс санхүүжих	25.3	24.7
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	25.3	24.7
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	28.6	28.6
Үндсэн үйл ажиллагааны орлогоос	1.1	1.1
Туслах үйл ажиллагааны орлогоос	0.4	0.4
Сум хөгжүүлэх сангийн орлого	90.3	90.6
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	27.1	27.1
ЭХ ҮҮСВЭРИЙН НИЙТ ДҮН	2191.3	2388.2

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1412.0, орон нутгийн төсвөөс 423.0, орон нутгийн татварын болон татварын бус орлого 134.8, ОХНС-ийн санхүүжилт 77.3, ЭМДС-аас санхүүжих 24.7, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1.1, туслах үйл ажиллагааны орлогоос 0.4 сая, сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөр 90.6, урьд оны үлдэгдлээс 27.1 сая төгрөг нийт 2191.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2115.1 сая төгрөгийг зарцуулж 17.9 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2115.1 сая төгрөг буюу 97.3 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 7.6, Цэцэрлэгийн хүүхдийн хоол 10.3 сая, сум хөгжүүлэх сангийн зээл олголтыг хязгаарласнаар нийт 76.1 сая төгрөгөөр батлагдсан төсвийг хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 1.1, туслах үйл ажиллагааны орлого 90.7 сая төгрөгөөр тус тус батлагдаж гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогыг 1.1 сая, туслах үйл ажиллагааны орлогыг 91.0 сая төгрөгөөр нийт 92.1 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн. Нийт бүрдүүлсэн орлогын 80.9 сая төгрөгийг СХС-ийн зээл, 5.8 сая төгрөг зээлийн хүүгийн орлого, 3.9 сая төгрөгийг зээлийн хүүгийн алданги, 0.4 сая төгрөг нь ЕБС-ийн өөрийн орлого, ЗДТГ-ын өөрийн орлого 0.6 сая төгрөг, Соёлын төвийн орлого 0.5 сая төгрөг бүрдүүлэн 17.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Мөнххайрхан сумын ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 2021 оны 09 дугаар сарын 15-ны өдрийн 5/06 дугаар тогтоолд Мөнххайрхан сумын Төвлөрүүлэн захирагчийн тайлант онд 134.8 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 332.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 246.3 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 4. Сумын татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая.төгрөг/

Орлогын ангилал	2021 оны		Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Татварын нийт орлогын дүн	134.8	332.0	(197.2)
Нийт орлого ба тусламжийн дүн	134.8	332.0	(197.2)
Татварын орлого	132.8	328.9	(221.0)
Орлогын албан татвар	10.9	22.1	(11.2)
Хувь хүний орлогын албан татвар	8.9	3.0	5.9

Үйл ажиллагааны орлого	2.0	19.1	(17.1)
Херенгийн албан татвар	20.5	45.1	(24.6)
Үл хөдлөх эд херенгийн албан татвар			-
Бууны албан татвар	4.5	4.4	0.1
Иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого	16.0	15.8	0.2
Малын тоо толгойн албан татвар	-	24.9	(24.9)
Малын тоо толгойн албан татвар		24.9	(24.9)
Бусад татвар, төлбөр, хураамж	101.4	261.7	(160.3)
Бусад нийтлэг төлбөр, хураамж	3.8	3.0	0.8
Улсын тэмдэгтийн хураамж	2.5	1.2	1.3
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны	0.3	0.3	-
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1.0	1.5	(0.5)
Газрын төлбөр	0.4	0.8	(0.4)
Газрын төлбөр	0.4	0.8	(0.4)
Байгалийн нөөц ашигласны төлбөр	97.2	257.9	(160.7)
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	95.6	256.1	(160.5)
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.3	0.3	-
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	1.3	1.5	(0.2)
Татварын бус орлого	2.0	3.1	(1.1)
Нийтлэг татварын бус орлого	2.0	3.1	(1.1)
Торгуулийн орлого	2.0	3.1	(1.1)

Эх сурвалж: Мөнххайрхан сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт орлого 332.0 сая төгрөг буюу 197.2 сая төгрөгөөр давуулжээ. Орлого давсан шалтгаан нь үйл ажиллагааны орлого 17.1, малын тоо толгойн албан тавар 24.9, хог хаягдлын хураамж 0.5, газрын төлбөр 0.4, ан амьтны нөөц ашигласны төлбөр 160.5, байгалийн ургамал ашигласны төлбөр 0.2, хүү торгуулийн орлого 1.2 сая төгрөгөөр орлого давуулан биелүүлж, хувь хүний орлогын албан тавар 5.9, бууны албан тавар 0.1, иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого 0.2, улсын тэмдэгтийн хураамж 1.3 сая төгрөгөөр тасалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн тайлангаар ЭМДС-аас Ковид-19 цар тахлын илүү цаг урамшуулал, эмийн зардалд 128.3, БСУГ-аас ЕБС болон СӨБ-ийн байгууллагад ажиллаж байгаа багш нарын тэтгэмж 31.8, номын түрээсийн орлого 2.3, аймаг сумын ОНХС-гаас 119.7, тогтвортой хөгжлийн боловсрол сангаас 15.0, шүүхийн Тамгын газраас 0.3, БОГ-аас 0.4, Шим -Ус ХХК-наас 7.7, аймгийн ИТХ-аас 0.3, төсвийн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 11.8, хандиваар 9.5 төгрөгийг төвлөрүүлэн ажиллагаандаа зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Мөнххайрхан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай дараах асуудлууд байна. Үүнд:

1. Сум хөгжүүлэх сангаас 2010-2020 онуудад өссөн дүнгээр олгогдсон үндсэн зээл 535.6 сая, түүнд ногдох хүү 19.2 сая, алданги 11.9 сая төгрөг нийт 566.7 сая төгрөгөөс 2021 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар хүү 17.4 сая төгрөг, алданги 7.3 сая төгрөг, үндсэн зээл 418.0 сая төгрөг, зээлдэгч нас барсны улмаас шүүхийн шийдвэрээр чөлөөлсөн 3.0 сая төгрөг бүгд 445.7 сая төлөгдөж 120.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс анхаарал татахуйц он дамжиж олон жил байгаа 13 зээлдэгчийн 67.2 сая төгрөгийн авлага нь сангийн хөрөнгийн эргэцийг удаашруулж, хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.

2. Орон нутгийн хөгжлийн сангаас малжуулах төсөлд 2014 оноос эхлэн олгосон 49.9 сая төгрөг нь малчдаас малчдад мал хэлбэрээр он дамжин үргэлжилсэн гэх үр дүн нь тодорхой бус санхүүгийн тайланд авлагаар олон жил байсаар байгаад ИТХ болон Засаг даргын зүгээс дотоодын хяналт хийлгэж авлага барагдуулж орлогыг зохих дансанд төвлөрүүлэх шаардлагатай байна.

3. Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх тэмцэхтэй холбоотой хувь иргэн, ААН, байгууллагуудаас 0.8 сая төгрөгийн бэлэн мөнгө, 32.6 сая төгрөгийн бараа материал, 23.8 сая төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмж, нийт 57.2 сая төгрөгийн хандив цугларч 47.9 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж 9.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэжээ. Тайланд хугацаанд 233 хүн Ковид-19 цар тахлаар өвчилж 29.3 сая төгрөгийн нэг удаагийн эм, эмнэлгийн хэрэгсэл урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Мөнххайрхан сум 2021 онд аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 131 тоот тогтоолоор УТХО-аар 1921.9 төгрөгийн төсөвтэй Спорт цогцолборын барилга, ОНХС-аар авто машины гүүр 110.0 сая, хөл бөмбөгийн талбай 80.0 сая нийт 2831.9 төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн нь тайланд үлэмж нөлөө үзүүлсэн байна.

МУ-ын Засгийн газрын 43 дугаар тогтоолын дагуу “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад”... **тэвчиж болох зардлаар тооцсон** 728.3 сая төгрөгийн 10 хувь 72.8 сая төгрөгийн хэмнэлт гаргахаас 17.9 төгрөг төсөвт төвлөрүүлж үлдэх 54.8 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулсан зөрчил илэрлээ. Энэ нь Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны 43 дугаар тогтоолын 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасан заалтыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 157 мэдээллийг хугацаандаа оруулсан, тогтмол зардлуудын мэдээллийг хугацаа хоцроосон, дутуу мэдээлснийг аудитын явцад залруулж зөвлөгөө өглөө. Харин сум хөгжүүлэх сангийн Шилэн дансны нэгдсэн сайтад тусгай цэсгүйгээс мэдээлэл байршуулаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 274.6 сая төгрөгийн зөрчилд 2 акт 1 албан шаардлага, 10 зөвлөмжүүдийг хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Ковид-19 цар тахлаар олгогдсон санхүүжилт, сумын иргэдэд түгээсэн цэвэр усны хөнгөлөлтийн зарцуулалтыг нягтлан үзэх шаардлагатай.

3.12 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагыг аудитад хамруулан дүгнэлт гаргаж, 5 тайланг түүвэрт хамруулсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”-3 (сумын 12 жилийн сургууль, сумын хүүхдийн цэцэрлэг, ЭМТ) дүгнэлт гаргасан байна.

Мөнххайрхан сумын ТТЗ-ын нэгтгэлд хамрагдсан төсвийн шууд захирагчдын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 135.7 сая төгрөгийн 18 алдаа зөрчил илэрч, мянган төгрөгийн 33.6 сая төгрөгийн 12 алдааг залруулсан байна.

Залруулагдаагүй 102.1 сая төгрөгийн алдаа зөрчлөөс 0.8 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 төлбөрийн акт тогтоон, 5.9 сая төгрөгийн 4 алдаа зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна. Нийт алдаа зөрчил, шийдвэрлэлтийг хүснэгтээр харуулбал:

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	12 жилийн сургууль	11	111.6	8	31.1	1	0.5	-	-	2	80
2	Хүүхдийн цэцэрлэг	6	18.2	4	2.5	1	0.3	-	-	1	15.4
3	ЭМТ	1	5.9	-	-	-	-	-	-	1	5.9
	Дүн	18	135.7	12	33.6	2	0.8			4	101.3

Эх сурвалж: Мөнххайрхан сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

4. Нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 200.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 30.7 сая төгрөгийн алдааг залруулж, 1.0 сая төгрөгийн 3 алдаа зөрчилд төлбөрийн акт, 67.2 сая төгрөгийн 1 алдаа зөрчилд албан шаардлага, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 103.0 сая төгрөгийн 4 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- ЗДТГ-ын ажилтан албан хаагчдын унаа болон албаны машинд шатахуун олгосон бичиг, явсан ажлын тайлан, жолоочийн тооцооны хуудсыг бичүүлж явсан албан тушаалтнаар гарын үсэг зуруулж баталгаажуулаагүй холбоотой 11.3 сая төгрөг,
- И баримт болон анхан шатны баримт дутуу ажил гүйлгээ холбоотой 15.1 сая төгрөг,
- Бараа материалыг нярвын тайланд тусгалгүй шууд зарлагдсантай холбоотой 3.7 сая төгрөг нийт 30.1 сая төгрөгийг ЗДТГ-ын 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 3/31 тоотыг үндэслэн залруулагдлаа.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 30.1 сая төгрөгийн залруулга хийж, залруулсан 2022 оны 03 дүгээр сарын 10-ны 3/31 тоот албан бичгийг үндэслэн санхүүгийн тайланд залруулга хийсэн болно.

4.1 Төлбөрийн акт

4.1.1 Сумын Засаг даргын орлогч, сан хариуцсан мэргэжилтэн, ЗДТГ-ын жолооч нарт албан томилолт, цалин илүү олгосонтой холбоотой 279.3 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай 16 дугаар зүйлийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах” гэсэн хуулийн заалт, аудитын “Үнэн зөв байдал”, “Иж бүрэн” байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

4.2 Албан шаардлага

4.2.1. Зээлийн эргэн төлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлээ хугацаандаа төлөөгүй насжин он дамжин удааширсан 13 иргэнтэй холбоотой 67.2 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн зөрчил илэрлээ.

Энэ нь сум хөгжүүлэх сангаас олгох барьцаат зээлийн гэрээний 2.1.4-д "авсан зээл, түүний хүүгийн төлбөрийг энэхүү гэрээний хавсралтад заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд зээлдэгчийн харилцах данснаас үл маргах журмаар мөн зохих журмын дагуу зээлийг төлүүлэх, шаардлагатай бусад арга хэмжээ авна", 3.4-д "энэхүү гэрээтэй холбогдсон аливаа маргаан асуудлыг 2 тал хамтран оролцож шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэх боломжгүй бол асуудлыг Монгол улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

4.3.1 ОНХС-ийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг, иргэдийн саналд тусгагдаж эрэмбэлэгдээгүйгээр “Смарт Электрик Инженеренг” ХХК-нд 0.4 квт СИП цахилгааны шугам шинэчлэх зургийн үнэд 2.5 сая, ОНХС-гийн журмыг зөрчиж хувь хүний хашааны банзны үнэд 2.1 сая төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн нийт 4.6 төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Сангийн сайдын 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.7-ийн 3,4,5 дугаар заалтуудад нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Сангийн сайдын 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллаж хууль, журам зөрчсөн төсөл арга хэмжээнд зардал олгохгүй байх

4.3.2 Төсвийн гүйцэтгэл, төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Сумын төсөвт байгууллагын дүнгээр тогтмол зардлыг 97.5 сая төгрөгөөр төлөвлөж, төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан 97.1 сая төгрөгөөр, Төрийн сангийн зарлагын хуулгаар 89.8 сая төгрөгийн зардал гаргаж 7.3 сая төгрөгийг бусад бараа үйлчилгээний зардал гүйлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.7-д “энэ хуулийн 22.2-т заасан төсвийн ангиллын төрөл бүрээр дэлгэрэнгүй ангилал тогтоох, түүнийг төсвийн төлөвлөлт, тайлагналт, гүйцэтгэлд ашиглах журмыг санхүү,

төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно”, 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг мөрдөн ажиллах заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Эдийн засгийн ангиллын дагуу төсөвт журмын дагуу зохицуулалт хийж зардлыг санхүүжүүлэн, Төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв илэрхийлж тайлагнах

4.3.3. Тогтоолын хэрэгжилтийн талаарх асуудал

Илрүүлэлт: МУ-ын Засгийн газрын 43 дугаар тогтоолын дагуу “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад”... **тэвчиж болох зардлаар тооцсон** 728.3 сая төгрөгийн 10 хувь 72.8 сая төгрөгийн хэмнэлт гаргахаас 17.9 төгрөг төсөвт төвлөрүүлж үлдэх 54.8 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулсан зөрчил илэрлээ. Үүнээс сумын ЗДТГ 36.0 сая төгрөгийн хэмнэлт бий болгоогүй байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны 43 дугаар тогтоолын 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас **бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх** зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасан заалтыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

Өгсөн зөвлөмж Засгийн газрын тогтоолын холбогдох заалтыг мөрдөж ажиллах.

4.3.4 Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Соёлын төв ой комиссоос үнэ төлбөргүй өгсөн 0.3 сая төгрөгийн бараа материалын орлогыг ангилал буруу тайлагнасан н зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын холбогдох заалттай зөрчилдөж байна.

Өгсөн зөвлөмж : Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг 347 тоот тогтоолын дагуу бүртгэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Хүснэгт – 6.ТТЗ-ын түүвэрт хамрагдсан байгууллагын алдаа зөрчлийн бүртгэл /сая. төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мөнххайрхан ТТЗ	2	62.1							2	62.1
2	ЗДТГ	4	66.4	3	30.1	1	0.3				36.0
3	Соёлын төв	1	0.3							1	0.3
5	Сум хөгжүүлэх сан	1	67.2					1	67.2		
6	ОНХС	1	4.6							1	4.6
Дүн		9	200.6	3	30.1	1	0.3	1	67.2	4	103.0

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР